



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2022 оны 2 болон 3 дахь долоо хоног



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2022 оны 1-р сарын 19-ний байдлаар

2020 оноос эхлэн дэлхий нийтээр тархаад буй Ковид-19 цар тахал нь зөвхөн олон нийтийн эрүүл мэндийн бус глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд ихээхэн нөлөө, өөрчлөлтүүдийг гаргаж байна. Энэ цаг үед тулгараад буй асуудлууд, эдийн засгийн хямралыг тогтворжуулах зорилгоор олон улсад хэрэгжүүлж буй бодлогын арга барилуудын талаар Монголбанкнаас 2 долоо хоног тутам бэлтгэн хүргэдэг гадаад орчны тойм мэдээллийн 2022 оны анхны дугаарыг толилуулж байна. Энэ удаагийн танилцуулгад i) Олон улсын эдийн засагт өрнөж буй онцлох үйл явдлууд, ii) БНХАУ-ын эдийн засагт болсон голлох өөрчлөлт, iii) Түүхий эдийн зах зээлд гарсан өөрчлөлтийг

1

ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ ӨРНӨЖ БУЙ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

тоймлон орууллаа.

“Дэлхийн эдийн засгийн төлөв” тайланг шинэчлэн танилцууллаа

Дэлхийн банкнаас “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайлангийн 2022 оны 1-р сарын дугаарыг танилцууллаа. Тус тайлангийн агуулга 5 бүлэгтэй байна:

Дэлхийн эдийн засгийн төлөв

- Дэлхийн эдийн засгийн өсөлт 2021 онд 5.5 хувь гарах урьдчилсан тооцоотой байгаа бол 2022 онд 4.1 хувь, 2023 онд 3.2 хувьд хүрч саарах төлөвтэй байна. Үүнд, эрэлт, эдийн засгийн идэвхжилийг дэмжсэн макро бодлогууд цаашид үргэлжлэхгүй, цар тахлын өмнөх үеийн төлөвт эргэн шилжинэ гэж үзжээ. 2022 онд өндөр хөгжилтэй орнуудын үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт цар тахлын өмнөх үеийн трендэд эргэн хүрэх төлөвтэй байгаа бол эрчимтэй хөгжиж байгаа болон хөгжиж буй орнуудын хувьд эдгээр үзүүлэлтүүд цар тахлын өмнөх үеийнхээс мэдэгдэхүйц доогуур байхаар байна. Энэ нь 1) эдгээр

улс орнуудын эдийн засгаа дэмжих бодлогын орон зай хумигдсан, 2) цар тахлаас үүдсэн байнгын шинжтэй сөрөг үр дагавар, 3) вакцинжуулалтын түвшин доогуур байгаа зэргээс шалтгаална гэж үзжээ.

- Эдийн засгийн өсөлтийн төсөөллийг муутгаж болзошгүй олон эрсдэлүүд байна. Тухайлбал, цар тахлын Омикрон хувилбараас үүдсэн эдийн засгийн хүндрэл, нийлүүлэлтийн гинжин хэлхээнд үүссэн гацаа, инфляцын хүлээлт өөрчлөгдөх, санхүүгийн дарамт, уур амьсгалтай холбоотой гамшиг болон урт хугацааны өсөлтийн бүрдүүлэгч хүчин зүйлс суларч байгаа зэргийг дурджээ.
- **Эрчимтэй хөгжиж буй болон хөгжиж буй орнуудын** хувьд шаардлага гарсан үед эдийн засгаа дэмжих бодлогын орон зай нь хумигдаж буй тул дээрх сөрөг эрсдэлүүд нь тэдгээр улсуудын “хатуу газардах” магадлалыг нэмэгдүүлж байна. Мөн эдгээр улсуудын бодлого



боловсруулагчдын хувьд инфляцын дарамт ихсэх, хөгжсөн орнуудын мөнгөний бодлогын чангаралтаас үүдэлтэй сөрөг үр дагаврыг зөөллөх, төсвийн орон зай хумигдах зэрэг сорилтуудтай нүүр тулж эхэллээ. Тиймээс урт хугацаанд эдийн засгийн өсөлтөө дэмжихийн тулд эрдэс түүхий эдээс хараат байдлыг бууруулах, орлогын болон хүйсийн тэгш бус байдлыг багасгах, эрүүл мэндийн болон уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хямралд бэлэн байх зэрэг чадваруудаа дээшлүүлэх чиглэлээр бодлогын шийдэмгий арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатайг онцолсон байна.

Бүс нутгийн эдийн засгийн төлөв

- Ихэнх эрчимтэй хөгжиж буй болон хөгжиж буй орнуудын хувьд 2022-23 оны эдийн засгийн өсөлт цар тахлын өмнөх 10 жилийн дундаж түвшинд эргэн очих төсөөлөлтэй байна. Гэвч энэхүү өсөлтийн түвшин нь цар тахлын үед бий болсон үйлдвэрлэлийн уналтыг нөхөхөд хангалтгүй ажээ. Харин хөгжсөн орнуудын хувьд эсрэгээрээ буюу цар тахлын үеийн үйлдвэрлэлийн уналтыг хангалттай нөхөж бүрэн сэргэхээр хүлээгдэж байна. Эрчимтэй хөгжиж байгаа болон хөгжиж буй орнуудын бүс нутгийн хувьд КОВИД-19 цар тахлын дэгдэлт илүү удаан үргэлжлэх, вакцинжуулалтын явц удаашралтай байгаа, санхүүгийн дарамт, түүхий эдийн үнэ төсөөлж байснаас доогуур байх, геополитикийн хурцадмал байдал болон нийгмийн эмх замбараагүй байдал, хүнсний аюулгүй байдал, цаг агаарын байдлаас үүдсэн хохирол зэрэг эрсдэлүүд тохиолдох магадлал өндөр

¹ Бага орлоготой орнуудад хөрвөх чадвар, төлбөрийн чадварын эрсдэл тулгарсан үед хөгжсөн орнууд зээлийн төлбөрийг түр хугацаанд хойшлуулж, өрөө дахин санхүүжүүлэх боломж олгодог тогтолцоо юм.

байгаа нь хэтийн төлөвт сөргөөр нөлөөллөө.

Цар тахлын дараа их хэмжээний өрийг хэрхэн шийдвэрлэх вэ? Өрийн асуудлыг шийдсэн өмнөх турилагуудаас авах сургамж

- Цар тахлаас шалтгаалсан 2020 оны эдийн засгийн хямралын үед дэлхий нийтээр өрийн хэмжээ огцом өссөн. Өрийн огцом өсөлт нь олон орныг өрөө дахин санхүүжүүлэхэд (бүтцийн өөрчлөлт хийх) хүргэсэн. **Их 20-ийн нийтлэг тогтолцоо**¹ нь бага орлоготой, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци (IDA)-ийн гишүүн орнуудад өрөө дахин санхүүжүүлэх боломж олгодог хэдий ч өрийн хэмжээг шууд бууруулах асуудлаас ихээхэн зайлсхийдэг. Түүхийг сөхвөл, Umbrella framework² нь олон хамтран зээлдүүлэгч орнуудын хувьд зээл хүссэн улсуудын өрийг чөлөөлөх асуудлыг ижил зарчмаар зохицуулдаг байв. Харин энэ удаад хамтын зээлээс илүүтэй улс орнууд дангаараа өгсөн зээл их байгаа тул ирээдүйд өрийг дахин санхүүжүүлэх асуудал өнгөрсөнтэй харьцуулахад илүү олон сорилттой тулгарах төлөвтэй байна.

Түүхий эдийн үнийн мөчлөг: Нөлөөлөгч хүчин зүйлс болон бодлого

- 2020 оны эхээр унаад байсан түүхий эдийн үнэ эргэн өсөж, зарим төрлийн түүхий эдийн үнэ түүхэн дээд түвшинд хүрсэн. Эрчим хүч, металлын үнэ ерөнхийдөө дэлхийн эдийн засгийн идэвхжилтэй уялдан өөрчлөгддөг бөгөөд сүүлийн жилүүдэд энэ хамаарал улам бүр нэмэгдэж байна. Цаашид түүхий эдийн үнийн хэлбэлзэл нь дэлхийн макро эдийн засгийн хандлага, түүхий эдийн нийлүүлэлтийн хүчин

² Umbrella framework – Хэд хэдэн дүрмийн үндсэн дээр бага орлоготой төлбөрийн дарамтад орсон орнуудын зээлийг дахин санхүүжүүлдэг тогтолцоо юм. Тухайлбал, 1956 онд байгуулагдсан Парис клуб, 1989 оны Brady Plan зэргийг дурдаж болно.



зүйлсээс хамаарахаар байна. Түүнчлэн олон түүхий эдийн хувьд үнийн хэлбэлзэл нь уур амьсгалын өөрчлөлт, хатуу түлшнээс татгалзах үйл явцаас үүдэн нэмэгдэх магадлалтай. Энэхүү түүхий эдийн үнийн савлагаанаас үүдсэн макро эдийн засгийн хэлбэлзлийг багасгахын тулд түүхий эд экспортлогч хөгжиж буй орнуудын хувьд эдийн засгийг тогтворжуулах бодлогоо сайжруулж, нөөц бүрдүүлж, экспорт болон хөрөнгө оруулалтыг төрөлжүүлэх замаар түүхий эдийн орлогоос хамаарах байдлаа бууруулах хэрэгтэйг зөвлөжээ.

КОВИД-19 цар тахлын дэлхий нийтийн орлогын тэгш бус байдалд үзүүлэх нөлөө


- КОВИД-19 цар тахал нь дэлхийн орлогын тэгш бус байдлыг нэмэгдүүлж, өмнөх 20 жилийн хичээл зүтгэлийн үр дүнг сааруулав. Хөгжиж буй орнуудад эдийн засгийн сэргэлт удаан байгаа нь улс хоорондын тэгш бус байдлыг 2010-аад оны эхэн үеийн түвшин рүү буцаах төлөвтэй байна. Мөн эрчимтэй хөгжиж байгаа болон хөгжиж буй орнуудад цар тахлын улмаас бага орлоготой хүн амын бүлгийн ажил эрхлэлт, орлого ихээр буурч байгаагаас улс доторх орлогын тэгш бус байдал нэмэгдэж байна. Дунд болон урт хугацаандаа инфляцын өсөлт, ялангуяа хүнсний үнийн хөөргөдөл, цар тахлаас үүдсэн боловсролын хоцрогдол зэрэг нь улс доторх тэгш бус байдлыг улам бүр гүнзгийрүүлж болзошгүй юм. Иймээс дэлхий дахины сэргэлтийг илүү тэгш хөгжлийн зам руу чиглүүлэхийн тулд цогц бодлогын багц шаардлагатай. Үүнд ногоон, дасан зохицох чадвар

өндөртэй (дархлаатай), хүртээмжтэй сэргэлтийг түргэсгэхэд олон улсын хамтын нийгэмлэгийн тусламж нэн чухал байна.

2021 онд хүнсний үнэ сүүлийн 10 жилийн хамгийн өндөр утгад хүрэв

- НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагаас зарладаг “Олон улсын хүнсний үнийн индекс³” 2021 оны 12 сард 133.7-д хүрч өмнөх оны мөн үеэс **23.1 хувиар** өслөө (Зураг 1). Хэдийгээр тус индекс 12-р сард өмнөх сараас ялимгүй буурсан боловч сүүлийн 10 сар дараалан өмнөх оны мөн үеэс 20-оос дээш хувиар өсөөд байна. Энэ хугацаанд бүрэлдэхүүн хэсгүүд бүгд өсөж байсны дотор тос, тосон бүтээгдэхүүн, элсэн чихэр, үр тарианы үнийн өсөлт хамгийн өндөр нөлөө үзүүлжээ (Зураг 2).

Зураг 1. Олон улсын хүнсний үнийн индекс




Эх сурвалж: НҮБ-ийн Хүнс хөдөө аж ахуйн байгууллага

³ Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, үр тариа, тос, тосон бүтээгдэхүүн, элсэн чихэр зэрэг бүтээгдэхүүнээс бүрддэг



Зураг 2. Зарим бүтээгдэхүүний жилийн инфляц



Эх сурвалж: НҮБ-ийн Хүнс хөдөө аж ахуйн байгууллага

Хүнсний инфляцын дэд бүлгүүдийн үнийн өөрчлөлтийг авч үзвэл:

- **Үр тарианы үнэ.** 2021 оны 12-р сард дэлхийн өмнөд хэсэгт **улаан буудайн** ургац хураалтын үе таарсан тул нийлүүлэлт нэмэгдэж, үүний зэрэгцээ эрэлт саарсан нь оны сүүлийн сард үр тарианы үнэ буурах шалтгаан боллоо. Харин Бразилд үргэлжилж буй ган, эрдэнэ шишийн эрэлт өндөр байгаа зэрэг нь **эрдэнэ шишийн** үнэ өндөр хэвээр хадгалагдахад нөлөөлөв. Эрдэнэ шишийн зах зээлийн эерэг нөлөөгөөр **Соргумын**⁴ үнэ ч мөн өссөн байна. Харин **будааны** үнэ эрэлт буурсан болон гол нийлүүлэгч улсуудын ханш ам.долларын эсрэг суларсан зэргээс шалтгаалан 2021 оны 12-р сард бага зэрэг буурав.

Өмнөх оныг **бүхэлд нь харвал** үр тарианы үнэ 2020 оноос 27.2 хувиар өссөн бөгөөд энэ нь 2012 оноос хойших хамгийн өндөр өссөн жил болж бүртгэгдлээ. Эрдэнэ шиш болон улаан буудайн үнэ өмнөх оноос харгалзан 44.1 хувь, 31.3 хувиар өссөн нь эрэлт өндөр, гол нийлүүлэгч улсуудын нийлүүлэлт хязгаарлагдмал (ялангуяа улаан буудайн хувьд) байсантай шууд холбоотой

байна. Харин 2021 онд үнэ нь буурсан ганц бүрэлдэхүүн хэсэг нь будаа (4 хувиар буурсан) юм. Үүнд, 2021 онд олон улсын тээврийн үнэ өссөнөөс шалтгаалж хэрэглэгчид хүрэх зардал нэмэгдсэн хэдий ч будааны нийлүүлэлт өндөр байсан тул тэрхүү тээврийн зардлыг нийлүүлэгч тал үүрч, будааны үнийг бууруулсан байна.

- **Тос, тосон бүтээгдэхүүний үнэ.** Тос, тосон бүтээгдэхүүний үнэ 2021 оны 12-р сард өмнөх сараас 3.3 хувиар буурав. Тухайлбал, дал модны тос болон наранцэцгийн тосны үнэ 12 сард хямдарсан байна. Дэлхий нийтэд цар тахлын дэгдэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор олон улсад болгоомжлол үүсэж, эрэлт саарсан нь наранцэцгийн тос, дал модны тосны үнэ буурахад нөлөөллөө. Харин шар буурцгийн тос, рапсын тосны үнэ 12-р сард өмнөх сараас өөрчлөлтгүй буюу өндөр хэвээр хадгалагдахад эдгээр тосны нийлүүлэлт хомс, Энэтхэгийн эрэлт өндөр байсан нь нөлөөлөв.

2021 оныг **бүхэлд нь дүгнэвэл** тос, тосон бүтээгдэхүүний үнэ өмнөх оны дунджаас 65.8 хувиар өсөж, түүхэн хугацааны рекорд тогтоов.

- **Сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ** (хуурай сүү, бяслаг, цөцгийн тос, өрөм). Сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 2021 оны 12-р сард өмнөх сараас 1.8 хувиар өсөв. Баруун Европ болон далайн орнуудын сүүний үйлдвэрлэл буурсан нь дэлхий нийтийн сүүний нийлүүлэлтийг бууруулсны зэрэгцээ эрэлт өндөр байсан тул цөцгийн тос, хуурай сүүний үнэ үргэлжлэн өсөв. Баруун Европт сүүний үйлдвэрлэлээс илүүтэй бяслаг үйлдвэрлэж нийлүүлсэн нь бяслагийн нийлүүлэлтийг нэмэгдүүлж, улмаар бяслагийн үнэ буурав. 2021 онд сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ өмнөх оны

⁴ Sorghum



дунджаас 16.9 хувиар өсжээ. Бүтэн жилийн туршид эрэлт өндөр байсан (тэр дундаа Ази тивээс) болон голлох үйлдвэрлэгч бүсүүдээс нийлүүлэлт хомс байсан нь ийнхүү үнэ өсөх шалтгаан боллоо.

өссөн тул үнэ нь буурав. Мөн хонины махны далайн орнуудаас нийлүүлэх нийлүүлэлт өссөн тул үнэ буурахад нөлөөлсөн. Гахайн махны үнэ сүүлийн 6 сар дараалж буураад байгаа бөгөөд цаашид ч буурах хүлээлттэй байна. Учир нь БНХАУ-д гахайн мялзан өвчин багасаж, гахайн махны үйлдвэрлэл, экспорт өндөр байгаа нь цаашид үргэлжлэх хүлээлттэй байна. 2021 онд махны үнэ өмнөх оны дунджаас 12.7 хувиар өндөр байв. Бүрэлдэхүүн хэсгүүдийн авч үзвэл хонины махны үнэ хамгийн ихээр өссөн бөгөөд үхрийн мах, шувууны махны үнийн өсөлт удаалж байна. Харин гахайн махны үнэ өмнөх оноос буурчээ.

- **Элсэн чихрийн үнэ.** Өмнөх оны сүүлийн сард элсэн чихрийн үнэ 11-р сараас 3.1 хувиар буурчээ. КОВИД-19

- **Махны үнэ** (үхэр, хонь, шувуу, гахай). Махны үнэ 2021 оны 12-р сард өмнөх сарын орчимд, өмнөх оны мөн үеэс 17.4 хувиар өндөр байв. Шувууны махны хувьд экспортлох боломжтой хэмжээ

цар тахлын Омикрон хувилбар тархаж эхэлсэнтэй холбоотойгоор олон бүс нутагт хязгаарлалтын арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа нь элсэн чихрийн эрэлтийг сааруулж, ийнхүү үнэ буурахад хүрлээ. Түүнчлэн, Бразилын реал ам.долларын эсрэг суларсан, этилийн үнэ буурсан зэрэг нь элсэн чихрийн үнэ буурах өөр шалтгаанууд байв. 2021 онд элсэн чихрийн үнэ өмнөх оны дунджаас 37.5 хувиар нэмэгдэв. Оны туршид Бразил дахь элсэн чихрийн үйлдвэрлэл бага байж, энэ хугацаанд эрэлт өндөр байснаар үнэ ийнхүү өсөж, 2016 оноос хойших хамгийн өндөр өсөлт болж бүртгэгдэв.

Эх сурвалж:

1. *Food and Agriculture Organization of the UN, World Food Situation*
2. *World Bank, Global Economic Prospects, Jan, 2022*

2

БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ БОЛСОН ГОЛЛОХ ӨӨРЧЛӨЛТ

- БНХАУ-ын эдийн засаг 2021 онд 8.1 хувиар тэлэв. Тухайлбал, үндсэн хөрөнгийн хуримтлал 2021 онд өмнөх оноос 4.9 хувь, боловсруулах салбарт оруулсан хөрөнгө оруулалт 13.5 хувиар, үл хөдлөх салбарт оруулсан хөрөнгө оруулалт 4.4 хувиар, дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалт 0.4 хувиар тус тус өссөн байна. Харин Тэг-КОВИД бодлогын нөлөөгөөр өрхийн хэрэглээ хүлээлтээс бага байж, худалдааны салбар 1.7 хувиар өсөв.
- БНХАУ-д цар тахлын Омикрон хувилбар тархаж байгаагай

холбоотойгоор олон улсын нөлөө бүхий 2 автомашин үйлдвэрлэгч компанийн үйлдвэрүүд энэ оны 1-р сарын 10-аас ажиллаж байна. Тодруулбал, Тяньжин мужид Омикрон хувилбарын

халдварын тохиолдлууд бүртгэгдсэн бөгөөд Тэг-КОВИД бодлогын хүрээнд тус мужийн удирдлагууд иргэдээ хэд хэдэн удаагийн бүх нийтийн халдвар илрүүлэх тестэд хамруулаад байна. Тяньжин мужид байрлах Тоёота, Фолксваген компанийн үйлдвэрийн ажилчид дээрх бүх нийтийн



шинжилгээнд хамрагдах, шинжилгээний хариу удаж гарч байгаа зэргээс шалтгаалан хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэл үүсжээ. Цаашид ч энэ байдал үргэлжилж, олон улсын автомашин үйлдвэрлэлийн түвшинд эргэн хүрэхээргүй байна. БНХАУ-ын хувьд жилдээ дотоод, гадаадын үйлдвэрүүдийн нийлсэн нийт 25 сая ширхэг автомашиныг үйлдвэрлэдэг бөгөөд энэ нь дэлхийн нийт үйлдвэрлэлийн гуравны нэгтэй тэнцэх дүн юм. Түүнчлэн, БНХАУ нь автомашин үйлдвэрлэлийн эд анги нийлүүлдэг томоохон тоглогч бөгөөд тус улсын одоогийн хэрэгжүүлж буй бодлогоос үзэхэд цахилгаан автомашин

гинжин хэлхээнд урт хугацааны доголдол үүсэх эрсдэлтэйг шинжээчид анхааруулж байна. Фитч агентлагийн мэдээнээс үзэхэд дээрх нөхцөл байдлаас шалтгаалан олон улсын автомашин үйлдвэрлэл дараа он хүртэл хэвийн үйлдвэрлэлд үүсээд буй батарейны дутагдал цаашид улам хүндрэх магадлалтай байна.

Эх сурвалж:

1. Bloomberg, [Top Carmaker Shutdowns Hint More to Come in Covid-Zero China](#)
3. CNBC, [China's economy grew 8.1% in 2021 compared to a year ago](#)
4. ING, [China will grow faster in 2022 than it did in 4Q21 with easier monetary and fiscal policy](#)
5. Reuters, [China cenbank to roll out more policy moves to stabilise growth](#)

3 ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ

Коксжих нүүрсний зах зээл

- **Үнэ:** БНХАУ-ын аж үйлдвэрийн мужуудад коксжих нүүрсний үнэ ахин нэмэгдлээ. 2022 оны 1-р сарын 14-ний өдрийн байдлаар Хэбэй мужид коксжих нүүрсний үнэ өмнөх хоёр долоо хоногоос тонн тутамд 400 юаниар нэмэгдэж 3,160 юань (498\$), Шаньси мужид 100 юаниар нэмэгдэж 2,960 юань (467\$), Таньжин боомтод 220 юаниар нэмэгдэж 2,930 юань (462\$)-д хүрээд байна.
- **Эрэлт:** Зарим мужуудад байгаль орчны хяналт зөөлөрч, 2022 оны 1-р сарын 14-ний байдлаар ган хайлуулах үйлдвэрүүдийн хүчин чадлын ашиглалт өмнөх оны эцсээс 2 нэгж хувиар нэмэгдэж 79.9 хувьд хүрэв. Ийнхүү гангийн үйлдвэрүүд төмөр хайлуулахад шаардлагатай коксжих нүүрсний худалдан авалтаа нэмэгдүүлж, коксжих нүүрсний эрэлт нэмэгдлээ.
- **Нийлүүлэлт:** Коксжих нүүрсний нийлүүлэлт өмнөх хоёр долоо хоногоос

буураад байна. Тухайлбал, SXcoal судалгааны байгууллагын судалгаанд хамрагдсан нүүрсний үйлдвэрүүдийн хүчин чадлын ашиглалт 1-р сарын 14-ний байдлаар өмнөх хоёр долоо хоногоос 3.0 нэгж хувиар буурч 98 хувьд хүрээд байна. Хүрээлэн буй орчны хяналт

зөөлөрснөөр зарим нүүрсний уурхайн үйл ажиллагаа эрчимжсэн ч Шаньси муж болон баруун хойд хэсгийн уурхайнуудад түүхий эд материал хомсдож, нүүрсний олборлолт буураад байна. Түүнчлэн, Шаньси мужийн Чанжид баглаатай жимснээс КОВИД-19 илэрснээс шалтгаалж, тус бүс нутгийн уурхайнуудын үйл ажиллагааг зогсоожээ.

- **Нөөц:** Нүүрсний эрэлт нийлүүлэлтээс ялимгүй давсны улмаас нүүрсний үйлдвэрүүдийн нөөц бага хэмжээгээр буурлаа. Тодруулбал, гангийн үйлдвэрүүд коксжих нүүрсний худалдан авалтаа нэмэгдүүлж, эрэлтийг



нэмэгдүүлсэн бол зарим нүүрсний уурхайнуудын үйл ажиллагаа зогсож, нүүрсний нийлүүлэлт буураад байна. Тухайлбал, Sxcoal байгууллагын судалгаанд хамрагдсан үйлдвэрүүдийн нөөц 2021 оны 1-р сарын 14-ний өдрийн байдлаар өмнөх хоёр долоо хоногоос 10 мянган тонноор буурч 800 мянган тонн болжээ.

- **Цаашдын хүлээлт:** БНХАУ-ын өвлийн олимп болох нь тээвэр, логистикт хүндрэл учруулна гэж гангийн үйлдвэрүүд үзэж байна. Иймд тэд нүүрсний нөөцөө өвлийн олимпоос өмнө нэмэгдүүлэх хүлээлттэй байгаа ажээ. Нөгөө талаас коксжих нүүрсний үйлдвэрүүд олборлолтоо нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал тул нүүрсний үнэ өсөх хүлээлттэй байна.

Эх сурвалж:

1. *SX Coal, Weekly Update, Monday 17th Jan, 2022*

Монголын нүүрсний экспорт

- Монголд цар тахлын Омикрон хувилбар илэрснээс хойш Гашуунсухайт-Ганцмод боомтоор нэвтэрсэн ачааны машины хоногийн дундаж тоо төдийлөн нэмэгдээгүй хэвээр үргэлжлэв. Энэ оны 1-р сарын 14-ний байдлаар тус боомтоор 100 орчим ачааны автомашин нэвтэрчээ. Хилээр нэвтрэх ачааны автомашины тоо огцом буурснаас шалтгаалж тус боомтын үнэ өмнөх хоёр 7 хоногоос тонн тутамд 230 юаниар нэмэгдэж 1,990 юаньд (314\$) хүрсэн байна.
 - Шивээхүрэн-Сэхэ боомт хаалттай хэвээр байгаа бөгөөд тус боомт дээрх коксжих нүүрсний үнэ өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй, 1,550 юань (\$243) хэвээр байна.
2. *Reuters, [Copper prices rise as China signals more policy support](#)*
 3. *Reuters, [Gold jumps 1% on subdued dollar, palladium bounces 7%](#)*



Хүснэгт 2. Экспортын гол нэрийн түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн өөрчлөлт

Бодит гүйцэтгэл						
	Үнэ (\$) 2022/1/20	Өөрчлөлт				Товч тайлбар
		өдрийн	7 хоногийн	сарын	жилийн	
Зэсийн үнэ	9'990	1.5%	0.3%	5.8%	24.2%	Нэг тонн зэсийн үнэ 1-р сарын 20-ны байдлаар 9990 долларт хүрэв. БНХАУ-ын Ардын банкны Дэд Ерөнхийлөгч Лю Гуочян 1-р сарын 18-ны өдөр цаашид заавал байлгах нөөцийн хувийг бууруулж мөнгөний бодлогыг зөөллөж, эдийн засгаа дэмжинэ гэсэн мэдэгдэл хийсний дараа зэсийн үнэ ийнхүү нэмэгдэв.
Төмрийн хүдрийн үнэ	129	1.3%	1.0%	13.4%	-24.0%	Нэг тонн төмрийн хүдрийн үнэ 129 болж нэмэгдлээ. БНХАУ-ын Ардын банк мөнгөний бодлогоо цаашид зөөллөх мэдэгдэл хийсэн, мөн тус улсын Засгийн газраас дэд бүтцийг дэмжихээр болсон төмрийн хүдрийн эрэлт, үнэ ийнхүү өсөхөд нөлөөллөө.
Алтны үнэ	1'839	-0.1%	0.9%	2.7%	-1.7%	Нэг унц алтны үнэ 1-р сарын 20-ны байдлаар 1839 долларт хүрч өсөв. Хэдийгээр ХНБ-наас бодлогын төлөвөө чангаруулах талаар мэдэгдээд байгаа ч Украин, Ойрх Дорнодын улс төрийн хурцадмал байдлаас шалтгаалж алтны үнэ нэмэгдэв.
Газрын тосны үнэ (Брент)	88	-0.1%	4.6%	23.6%	57.6%	Нэг баррель Брент маркийн газрын тосны үнэ 1-р сарын 20-ны байдлаар 88 ам.долларт хүрч нэмэгдэв. ОХУ, Украины улс төрийн асуудал, Йемений Хоути босогчид Арабын нэгдсэн улсын томоохон газрын тос нийлүүлэгч рүү дайрсан зэргээс шалтгаалж газрын тосны үнэ ийнхүү нэмэгдэв. Мөн ОПЕК+ нэгдлийн зүгээс өдөрт 400 мянган баррель газрын тос нэмэлтээр нийлүүлэх амлалтаа биелүүлэхэд хүндрэлтэй байгаа талаар мэдэгдээд байна.